



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 379

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4, 6.5, 6.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дархан-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 7 нэрийн нийт 320,939,116.62 (гурван зуун хорин сая есөн зуун гучин есөн мянга нэг зуун арван зургаан төгрөг жаран хоёр мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. "Дархан-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга М.Энхболд, гүйцэтгэх захирал Б.Баясгалан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр худалдах, орлогод авах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Акталж данснаас хассан тээврийн хэрэгслийг улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА




З.МЭНДСАЙХАН

Д.НАРАНГЭРЭЛ

000722

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 07 дугаар сарын 06-ний өдрийн 379
дугаар тогтоолын хавсралт



**"ДАРХАН-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт**

д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Ашиглал тад орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Сэлбэгээр худалдах, орлогод авах доод үнэ /төгрөг/
1	Ачаа тээвэрлэгч 41-72 ДАХ арлын дугаар 26539	1998	28,439,233.00	800,000.00
2	Индүү ДУ-16Г 36-68 УБ арлын дугаар 000186	1989	3,972,600.00	800,000.00
3	Ачааны машин 05-32ДАУ арлын дугаар арлын дугаар LGAXBH 1MX71021285	2007	193,022,087.73	800,000.00
4	Ачааны машин 35-01 УББ арлын дугаар YA10896	1997	52,000,000.00	800,000.00
5	Ачааны машин 05-81 ДАУ арлын дугаар NPR71L7407100	2010	13,636,363.64	800,000.00
6	Старекс 05-41ДАУ арлын дугаар KMJWWN7HP5U656670	2007	18,752,792.00	800,000.00
7	Трактор 40-81 УБ арлын дугаар 195-02-TD20	1999	11,116,040.25	500,000.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		320,939,116.62 (гурван зуун хорин сая есөн зуун гучин есөн мянга нэг зуун арван зургаан төгрөг ерэн хоёр мөнгө)	5,300,000.00 (таван сая гурван зуун мянга)